



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 82 ВАГ-БНАТАГ-2018/02-ГА Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Баянхонгор аймгийн Замын сангийн хөрөнгийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Эрдэм” ахлах сургуулийн гаднах авто зогсоолын ажлыг “Баялаг номгон” ХХК нь 2017 оны 07-р сарын 16-аас 2017 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөр гүйцэтгэж, хүлээлгэн өгөх байсан ч дулааны станцын инженерийн шугамын газрын маргаантай асуудлаас болж ажил хойшлогдсон ба тус компани нь гэрээнд заасны дагуу урьдчилгаанд олгосон 8,0 сая төгрөгөөр ажил хийгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам” –ын 5.2-д заасан “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана”, мөн журмын 5.4 –т “Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч хариуцана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.



Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны

2518125

А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. “Баялаг номгон” ХХК-аар “Эрдэм” ахлах сургуулийн гаднах авто зогсоолын ажлыг хийж гүйцэтгүүлж, зөрчлийг арилгах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ХОХБТХ-ийн дарга Д.Ихбаяр, мэргэжилтэн А.Дорж нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

 БИЧСЭН: АУДИТОР <i>[Signature]</i> П.МӨНХ-ЭРДЭНЭ Б.НАРАНГЭРЭЛ	 ЗӨВШӨӨРСӨН: ХОХБТХ-ИЙН ДАРГА <i>[Signature]</i> Д.ИХБАЯР МЭРГЭЖИЛТЭН <i>[Signature]</i> А.ДОРЖ
--	--

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 83 VAG-БНАТАГ-12018/02-ГА Номгон

Г Зөрчил арилгуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Баянхонгор аймгийн Замын сангийн хөрөнгийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Их богд зам” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Баянхонгор сумын ЗДТГ-ын гаднах явган замын ажлын гүйцэтгэлийг шалгахад 3 байршилд явган замын ажил дутуу хийгдсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 5.2-д заасан “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

2518127

1. Баянхонгор сумын ЗДТГ-ын гаднах явган замын дутуу ажлыг “Их богд зам” ХХК-аар хийж гүйцэтгүүлж, зөрчлийг арилгах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ХОХБТХ-ийн дарга Д.Ихбаяр, мэргэжилтэн А.Дорж нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

БИЧСЭН:
АУДИТОР *П. Мөнх-Эрдэнэ* П.МӨНХ-ЭРДЭНЭ
Б.НАРАНГЭРЭЛ
6417143544
Б-ОА00067 3007423

ЗӨВШӨӨРСӨН:
ХОХБТХ-ИЙН ДАРГА Д.ИХБАЯР
МЭРГЭЖИЛТЭН А.ДОРЖ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 84

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Баянхонгор аймгийн Замын сангийн хөрөнгийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тээврийн хэрэгслийн бодит тоог аймгийн Авто тээврийн төвтэй хамтарч төлөвлөлтийг үнэн зөв хийгээгүй, ашиглагдахгүй байгаа тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах ажлыг үр дүнтэй зохион байгуулаагүй нь өмнөх онуудын аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.6-д заасан “Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгуулахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. “Авто замын санд төвлөрөх АТБӨЯХАТ-ын орлого болон зам ашигласны хураамжийг аймгийн Авто тээврийн төвд бүртгэлтэй автомашины судалгаанд үндэслэн бодитой төлөвлөж, холбогдох байгууллагуудтай хамтарч төлөвлөсөн орлогыг бүрэн бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.

2518129

2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 12 дугаар сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Засаг дарга дарга Г.Батжаргал, СТСХ-ийн дарга С.Байгалмаа, аймгийн Авто тээврийн төвийн дарга С.Амармөнх нарт хариуцуулав.

АУДИТОР

БИЧСЭН:

П.МӨНХ-ЭРДЭНЭ

Б.НАРАНГЭРЭЛ

1115206735

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Г.БАТЖАРГАЛ

СТСХ-ИЙН ДАРГА
С.БАЙГАЛМАА

АВТО ТЭЭВРИЙН ТӨВИЙН ДАРГА
С.АМАРМӨНХ

1115206735

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.